



“ТӨРИЙН ОРОН СУУЦНЫ КОРПОРАЦИ” ТӨХХК-Н ВЭБ САЙТ ШИНЭЧЛЭХ АЖЛЫН ДААЛГАВАР

1. Нийтлэг үндэслэл

1.1. Баримт бичгийн нэр

“Төрийн орон сууцны корпораци” ТӨХХК-ийн албан ёсны вэб сайт гүйцэтгэх ажлын даалгавар

1.2. Захиалагч байгууллага

“Төрийн орон сууцны корпораци” ТӨХХК

1.3. Төслийн зорилго

Төрийн орон сууцны корпораци ТӨХХК-ийн үйл ажиллагаа, хэрэгжүүлж буй хөтөлбөр, төсөл, үйлчилгээ, мэдээ мэдээллийг иргэд, харилцагч байгууллага, хөрөнгө оруулагч болон бусад оролцогч талуудад шуурхай, ойлгомжтой, ил тод хүргэх, цахим орчинд байгууллагын нэгдсэн мэдээллийн суваг бүрдүүлэх, хэрэглэгчдэд үйлчилгээг хялбар авах боломж олгох зорилго бүхий албан ёсны вэб сайтыг зохион бүтээж, хөгжүүлэн нэвтрүүлэхэд энэхүү ажлын даалгаврын зорилго оршино.

1.4. Хамрах хүрээ

- Судалгаа, төлөвлөлт;
- Мэдээллийн бүтэц, UX/UI зураглал;
- Програмчлал, хөгжүүлэлт;
- Контент байршуулах бэлтгэх;
- Туршилт, нэвтрүүлэлт;
- Сургалт, баталгаа, мэргэжлийн тусламж үйлчилгээ;
- Өргөтгөл, хөгжүүлэлт хийх нэмэлт боломжуудад хамаарна.

1.5. Төсөв: 19,500,000 төгрөг

2. Төслийн зорилт

Вэб сайт нь дараах зорилтыг хангана:

1. Байгууллагын албан ёсны мэдээллийг нэг цэгээс хүргэх;
2. Төсөл, хөтөлбөр, орон сууцны мэдээллийг иргэдэд ойлгомжтой хэлбэрээр танилцуулах;
3. Өргөдөл, хүсэлт, санал, гомдол, бүртгэл зэрэг харилцах сувгийг цахимжуулах;
4. Ил тод байдал, тайлагнал, мэдээ мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэх;
5. Гар утас, таблет, компьютер зэрэг бүх төрлийн төхөөрөмжөөс ашиглах боломжтой байх;
6. Цаашид нэмэлт модуль, цахим үйлчилгээ холбох боломжтой уян хатан бүтэцтэй байх.

3. Зорилтот хэрэглэгчид

Вэб сайтын үндсэн хэрэглэгчид:

- Иргэд, орон сууц худалдан авагч болон түрээслэгчид;
- Зорилтот хөтөлбөрт хамрагдах хүсэлтэй иргэд;
- Төрийн болон хувийн хэвшлийн хамтрагч байгууллагууд;
- Хөрөнгө оруулагчид;
- Хэвлэл мэдээллийн байгууллагууд;

- Ажил горилогсод;
- Байгууллагын дотоод хэрэглэгч, администраторууд.

4. Вэб сайтын үндсэн шаардлага

4.1. Ерөнхий шаардлага

Вэб сайт нь дараах ерөнхий шаардлагыг хангасан байна:

- Монгол хэл дээр үндсэн агуулгатай байх;
- Шаардлагатай тохиолдолд англи хэлний хувилбар нэмэх боломжтой байх;
- Responsive буюу бүх дэлгэцийн хэмжээтэй төхөөрөмжид нийцтэй байх;
- Орчин үеийн, байгууллагын өнгө төрхийг илэрхийлсэн дизайнтай байх;
- Хэрэглэгчдэд ойлгомжтой, цөөн алхмаар мэдээлэлд хүрэх навигацитай байх;
- Ачаалал хурдан, аюулгүй ажиллагаа хангасан байх;
- Хайлтын системд оновчлогдсон (SEO суурь шаардлага хангасан) байх;
- Контент удирдах хэсэгтэй (CMS) байх;
- Монгол кирилл фонт, тэмдэгтийн бүрэн дэмжлэгтэй байх.

4.2. Домэйн, хостингийн шаардлага

- Захиалагчийн эзэмшлийн домэйн дээр байршуулна;
- Найдвартай хостинг эсвэл серверийн орчинд суурилуулна;
- SSL сертификат суулгаж HTTPS горимд ажиллана;
- Нөөцлөлтийн тохиргоо хийсэн байна;
- Ирээдүйд ачаалал нэмэгдэхэд өргөтгөх боломжтой байна.

5. Вэб сайтын бүтэц, үндсэн цэсүүд

Санал болгож буй үндсэн бүтэц:

5.1. Нүүр хуудас

- Байгууллагын товч танилцуулга
- Онцлох мэдээ, зарлал
- Хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрийн товч мэдээлэл
- Шуурхай холбоосууд
- Видео/зурагт баннер
- Статистик үзүүлэлтүүд
- Санал хүсэлт илгээх хэсэг

5.2. Бидний тухай

- Байгууллагын танилцуулга
- Эрхэм зорилго, алсын хараа
- Үйл ажиллагааны чиглэл
- Удирдлагын мэндчилгээ
- Байгууллагын бүтэц
- Холбоо барих мэдээлэл

5.3. Мэдээ, мэдээлэл

- Цаг үеийн мэдээ
- Зар, мэдэгдэл
- Тендер, худалдан авалт
- Хэвлэлийн мэдээ
- Зураг, видео мэдээ
- Ангилал, хайлт, шүүлтүүр

5.4. Төсөл, хөтөлбөрүүд

- Хэрэгжиж буй төсөл
- Дууссан төсөл

- Орон сууцны хөтөлбөрүүд
- Байршил, хүчин чадал, үнэ, нөхцөлийн мэдээлэл
- Зураг, төлөвлөлт, танилцуулга файл
- Төсөл тус бүрийн дэлгэрэнгүй хуудас

5.5. Үйлчилгээ

- Орон сууцтай холбоотой үйлчилгээний мэдээлэл
- Материал бүрдүүлэлт
- Бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт
- Хүсэлт гаргах заавар
- Түгээмэл асуулт, хариулт

5.6. Ил тод байдал

- Хүний нөөцтэй холбоотой мэдээллүүд
- Үйл ажиллагаатай холбоотой мэдээллүүд
- Худалдан авах ажиллагааны мэдээллүүд
- Тушаал, шийдвэр
- Дүрэм, журам
- Нээлттэй өгөгдлийн файл байршуулах боломж

5.7. Цахим үйлчилгээ / Онлайн хүсэлт

- Санал, хүсэлт, гомдол хүлээн авах форм
- Хөтөлбөрт бүртгүүлэх форм
- Холбоо барих форм
- Онлайн хүсэлтийн төлөв шалгах боломж (хожмын өргөтгөлөөр)

5.8. Хууль, эрх зүй

- Холбогдох хууль тогтоомж
- Дүрэм, журам
- Засгийн газрын тогтоол, шийдвэрүүд
- Маягт, загвар татаж авах хэсэг

5.9. Нээлттэй ажлын байр

- Ажлын байрны зар
- Ажлын байрны тодорхойлолт
- CV илгээх боломж

5.10. Холбоо барих

- Байршлын зураг
- Хаяг
- Утас, и-мэйл
- Ажлын цагийн мэдээлэл
- Санал хүсэлтийн форм

6. Функциональ шаардлага

6.1. Хэрэглэгчийн хэсэг

Вэб сайтын хэрэглэгчийн хэсэг нь дараах боломжуудтай байна:

- Мэдээ, мэдээлэл унших;
- Төсөл, хөтөлбөрийн мэдээлэл үзэх;
- Хайлт хийх;
- Форм бөглөх, хүсэлт илгээх;
- Баримт бичиг, маягт татаж авах;
- Гар утас, таблет, компьютерээс жигд ашиглах;

- Нийгмийн сүлжээ рүү хуваалцах;
- Түгээмэл асуулт хариултын хэсэг ашиглах.

6.2. Админ хэсэг

Админ удирдлагын систем нь дараах боломжийг агуулна:

- Мэдээ, зарлал нэмэх, засах, устгах;
- Хуудас, цэс, дэд цэс үүсгэх;
- Төсөл, хөтөлбөрийн мэдээлэл оруулах;
- Зураг, видео, файл, PDF байршуулах;
- Баннер удирдах;
- Формоор ирсэн хүсэлтүүдийг харах, экспортлох;
- Хэрэглэгчийн эрх, түвшин удирдах;
- SEO гарчиг, тайлбар, URL тохируулах;
- Сайтын статистик болон хандалтын мэдээлэл холбох;
- Статистикийн dashboard
- Контент нийтлэх огноо, төлөв удирдах.

6.3. Хайлтын боломж

- Сайтын дотоод хайлттай байх;
- Мэдээ, төсөл, баримт бичиг, хууль эрх зүйн мэдээллээр хайлт хийх;
- Ангилал, огноо, түлхүүр үгээр шүүх боломжтой байх.

6.4. Форм болон бүртгэлийн модуль

- Санал хүсэлт хүлээн авах;
- Гомдол, өргөдөл хүлээн авах;
- Онлайн бүртгэлийн форм;
- Автоматаар и-мэйл мэдэгдэл очих;
- Өгөгдөл CSV/Excel рүү экспортлох боломжтой байх.

7. Функциональ бус шаардлага

7.1. Аюулгүй байдал

- HTTPS протоколтой байх;
- Админ хэсэгт нэвтрэх хамгаалалттай байх;
- SQL injection, XSS, CSRF зэрэг нийтлэг халдлагаас хамгаалсан байх;
- Нууц үгийг шифрлэн хадгалах;
- Хандалтын лог бүртгэдэг байх;
- Тогтмол нөөцлөлт хийх боломжтой байх.

7.2. Гүйцэтгэл

- Хуудасны ачааллын хугацаа оновчтой байх;
- Зураг, файл, кэшийн оновчлол хийсэн байх;
- Нэгэн зэрэг олон хэрэглэгч орсон үед хэвийн ажиллах чадвартай байх.

7.3. Хүртээмж

- Хэрэглэгчдэд ойлгомжтой интерфэйстэй байх;
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэд ашиглах боломжийг харгалзсан суурь хүртээмжтэй байх;
- Фонтын хэмжээ, өнгөний ялгарал ойлгомжтой байх.

7.4. Өргөтгөх боломж

- Ирээдүйд шинэ модуль нэмэх боломжтой;
- Төрийн болон бусад системтэй API-аар холбох боломжтой;

8. Дизайн, UX/UI шаардлага

- Байгууллагын өнгө төрх, лого, брэндбүүктэй нийцсэн дизайнтай байх;

- Цэвэр, төрийн байгууллагын албан ёсны хэв маягтай байх;
- Нүүр хуудас нь гол мэдээллийг шуурхай харуулах бүтэцтэй байх;
- Хэрэглэгчийн 3 хүртэл алхмаар шаардлагатай мэдээлэлд хүрэх логиктой байх;
- Мобайл хувилбарт бүрэн зохицсон байх;
- Баннер, зураг, дүрс, icon ашиглалтыг зохистой байлгах;
- Хөгжүүлэлтээс өмнө UX wireframe болон үндсэн дизайн загвар батлуулна.

9. Техникийн шаардлага

- Орчин үеийн, албан ёсны лицензтэй технологи ашиглах;
- Backend, frontend код нь цаашид хөгжүүлэлт хийхэд ойлгомжтой бүтэцтэй байх;
- CMS нь хэрэглэхэд хялбар, монгол хэл дээр контент оруулахад тохиромжтой байх;
- Source code, database, media asset, суурилуулалтын зааврыг захиалагчид хүлээлгэн өгнө;
- Git болон хувилбарын удирдлага ашиглах;
- API холболт хийхэд бэлэн архитектуртай байх.

10. Интеграцийн боломж

Шаардлагатай тохиолдолд дараах системүүдтэй холбох боломжтой байна:

- SMS мэдэгдлийн систем;
- Google Maps эсвэл түүнтэй адилтгах газрын зураг;
- Нийгмийн сүлжээний холбоос, feed;
- Аналитикийн систем;
- Төрийн үйлчилгээний нэгдсэн системүүдтэй холболт хийх боломж.

11. Контент бэлтгэл, шилжилт

- Захиалагч талаас текст, зураг, файл, лого, танилцуулга материал өгнө;
- Гүйцэтгэгч тал контентыг байршуулах загвар, бүтэц, форматын зөвлөмж өгнө;
- Хуучин сайтаас мэдээлэл шилжүүлэх шаардлагатай бол тохиролцсон хэмжээнд хийж гүйцэтгэнэ;
- Контент оруулах анхны тусламж, зааварчилгаа өгнө.

12. Туршилт, хүлээлгэн өгөх

Гүйцэтгэгч нь дараах ажлыг хийж хүлээлгэн өгнө:

- Функциональ туршилт;
- Responsive туршилт;
- Аюулгүй байдлын суурь шалгалт;
- Хөтөч хоорондын нийцлийн шалгалт;
- Алдааны засвар;
- Туршилтын үр дүн;
- Сургалтын тайлан;
- Ашиглалтын гарын авлага.

Хүлээлгэн өгөх баримт бичиг:

- Эх код;
- Өгөгдлийн сан;
- Техникийн баримт бичиг;
- Админ ашиглалтын заавар;
- Баталгаат хугацаа;
- Ажил хүлээлцсэн акт.

13. Хугацаа

Төслийн хэрэгжилтийн санал болгож буй үе шатыг 60 хоногт багтсан байхаар тооцож ирүүлэх

14. Баталгаат хугацаа, дэмжлэг

- Нэвтрүүлснээс хойш хамгийн багадаа 12 сарын баталгаат хугацаатай байх;

- Баталгаат хугацаанд гарсан програмын алдааг үнэ төлбөргүй засварлах;
- Контент удирдлагын систем ашиглах сургалт өгөх;
- Техникийн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх;
- Нэмэлт хөгжүүлэлтийг тусад нь гэрээгээр тохирох боломжтой байх.

15. Гүйцэтгэгчид тавигдах шаардлага

Гүйцэтгэгч байгууллага нь:

- Вэб сайт хөгжүүлэлтийн туршлагатай байх;
- Ижил төстэй байгууллагын веб систем хийж байсан туршлагатай бол давуу тал болно;
- UX/UI дизайн, backend, frontend, тест, нэвтрүүлэлтийн багтай байх;
- Баталгаат дэмжлэг үзүүлэх чадвартай байх;
- Товлосон хугацаанд чанартай гүйцэтгэх чадамжтай байх.